

ШИВЭЭГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

/2019.02.24-2019.03.25/

НЭГ: УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Шивээговь сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, цагдаагийн хэсэг сумын аж ахуйн нэгж байгууллагуудтай гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран ажиллах гурвалсан гэрээг байгууллаа.

Алдарт эхийн 1, 2-р зэргийн одон шинээр авах иргэдийн материалыг сумын ИТХТ-ын хурлаар хэлэлцүүлж алдарт эхийн 1-р зэргийн одонг 1 иргэн, 2-р зэргийн одонг 11 иргэнд олгохоор боллоо.

Сумын удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж албан байгууллагуудын мэдээлэлтэй танилцан байгууллагуудын удирдлагуудад холбогдох чиглэлийн дагуу хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.

Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн нээлтийг сумын "Малчдын зөвлөгөөн"-өөр эхэллээ. Зөвлөгөөнд аймгийн ХХААГ, МЭГ, Нийгмийн даатгалын хэлтэс, сумын ЗДТГ болон сумын 6 байгууллагын 18 албан хаагч 2018 оны ажлын тайлан, 2019 онд хийгдэх ажлаа танилцуулж, шинээр гарсан болон шинэчлэн өөрчлөгдсөн хуулиудаар мэдээлэл хийлээ. Уг арга хэмжээний үеэр хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулан сумын иргэд болон сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийг мах, сүү цагаан идээгээр хангадаг 13 малчин эмэгтэйчүүдийг шагнаж урамшууллаа. Мөн малчдынхаа дунд "АХА" танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулж, соёлын төвөөс урлагийн тоглолт, үдшийн цэнгүүнийг зохион байгууллаа.



Монгол Улсын Засгийн Газрын 2011 оны 339, 2017 оны 67 дугаар тогтоолуудын дагуу “Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх” зарлан мэдээллийн дуут дохиог 2019 оны 03 сарын 21-ны өдрийн 16:00 цагт сумын хэмжээнд зохион байгуулж сирень дохиог 3 удаа дуугаргаж дадлага сургуулилт хийлээ. Зарлан мэдээллийн дуут дохиогоор Төрийн Захиргааны болон аж ахуйн нэгж байгууллагын ажилчид, ЕБС-ийн сурагчид, цэцэрлэгийн хүүхдүүд, иргэдийг аюулгүйн 4 бүсэд шилжүүлэн байршуулж, үйл ажиллагаанд хяналт тавин ажилласан. Үүнд 16 төрийн болон төрийн бус байгууллагын 334 албан хаагч, 510 хүүхэд, 25 иргэн нийт 869 иргэд хамрагдсан.



“Хаялга” спорт клубын нэрэмжит Боксын тэмцээн 2019 оны 02-р сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулагдаж 7 аймгийн 19 багийн 170 гаруй тамирчид 16 жинд өрсөлдөж багийн дүнгээр 1-р байранд “Хаялга” спорт клуб, 2-р байранд Зэвсэгт хүчний “Алдар” спорт хороо, 3-р байранд СХД-ийн “Ихэр бээлий” клуб тус тус шалгарсан байна.





Жудо бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнд “Хаялга” спорт клубын жудо бөхийн 17 тамирчин хүүхдүүд оролцож 6 алт, 2 мөнгө, 5 хүрэл медаль хүртсэн амжилт гаргасан байна.

Аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан Гамшгийн бэлэн байдлын үзлэг, сургуулиалтад сумын мэргэжлийн ангийн 80 гаруй гишүүд бүрэн бүрэлдэхүүнээрээ хамрагдсан.



ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2019 оны 3-р сарын 25-ны өдрийн байдлаар орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 9389,7 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэл 12043,2 мянган төгрөг буюу 120 хувиар давж биелэсэн байна.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ

Өргөдөл, гомдол, санал хүсэлтийн 1-р улирлын мэдээг гаргаж аймгийн төрийн захиргаа удирдлагын хэлтэс гаргаж хүргүүлсэн. Үүнд: 2019 оны 1-р улирлын байдлаар Засаг дарга болон засаг даргын Тамгын газарт 34 өргөдөл, иргэний бүртгэлийн асуудлаар 87 нийт 121 өргөдөл хүлээн авсанаас 115 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж 1 өргөдөл дээд шатны байгууллагад шилжүүлж 5 өргөдөл шийдвэрлэгдэх шатандаа байна.

Цагдаагийн ерөнхий газраас хэрэгжүүлж буй "Нэг хором" аяны хүрээнд аймгийн цагдаагийн хэлтэс, сумын цагдаагийн хэсэг нартай хамтран иргэдэд зөрчлийн тухай хууль, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиудаар сургалт зохион байгуулж 168 иргэд хамрагдлаа.



БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ **3-Р СУРГУУЛЬ :**

МУБИС-ийн физик математикийн факультетын декан асан доктор Д.Цэрэндуламын нэрэмжит математикийн бүсийн олимпиад 2019 оны 02 сарын 16 өдөр Говьсүмбэр аймагт зохион байгуулагдаж 3-р сургуулиас нийт 44 суралцагч оролцсоноос IV ангийн төрлөөс Б.Жаргалмаа багштай 4в ангийн сурагч Т.Мөнхжин алт, Д.Учрал хүрэл, Ц.Одончимэг багштай 4а ангийн сурагч Ж.Тэлмүүн хүрэл медаль тус тус хүртсэн амжилтыг үзүүлсэн.



2018-2019 оны хичээлийн жилийн орос хэлний төрөлжсөн олимпиадын II даваа 02 сарын 22-ны өдөр аймагт зохион байгуулагдаж орос хэлний багш С.Эрдэнэчимэг, түүний шавь XII ангийн сурагч Д.Гантулга нар тэргүүн байранд шалгарч улсын олимпиадад оролцох эрхийн бичигээр шагнагдлаа.

Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэдалай агсны нэрэмжит математикийн олимпиадыг сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, нээн илрүүлэх зорилгоор сумын ИТХ, ЕБСургуультай хамтран IV-XII ангийн сурагчдын дунд 2 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж аврагуудыг шалгаруулан шагнаж урамшууллаа.



“Хаврын баяр-2019” урлагийн наадмыг 3 дугаар сарын 06 –нд найрал дуу, гоцлол дуу, гоцлол бүжиг, хамтлаг бүжиг, уран уншлагын төрлүүдээр I-III, IV-VI, VII-IX, X-XII–р ангиудын дунд зохион байгуулж төрөл тус бүрээс 1, 2-р байрыг шалгаруулан шагнаж урамшууллаа.




Ерөнхий боловсролын сургуулийн эмч хүүхдийн зөвлөл, залуу эмч бүлэгтэй хамтран 1-12 дугаар ангийн суралцагчид, эцэг, эхчүүдэд улаан бурхан, салхин цэцэг, менингокк өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж зөвлөгөө өгч ажилласан.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Эрүүл мэндийн төвд 42 өвчтөн хэвтэж үүнээс 12-н хүүхэд хэвтэн эмчлүүлж байна. Эмнэлгийн үйлчилгээ нь:

- Амбулаторийн үзлэг – 453
- Урьдчилан сэргийлэх- 1181
- Дуудлага-123

Эрүүл мэндийн яамнаас зохион байгуулсан “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” төслийн туршлага солилцох уулзалт, сургалтанд сумын Эрүүл мэндийн төвийн дарга хамрагдаж ЭМТ-д Мобайл технологийг нэвтрүүлэхээр болсон.



Говьсүмбэр аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх эмч, эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хорооноос зохион байгуулсан “Сайн туршлагаа хуваалцай” 7 сарын аяны нээлтийн өдөрлөг аймагт зохион байгуулагдаж сумын эрүүл мэндийн төвийн хамт олон амжилттай оролцож 2 туршлагыг нь улсад нэвтрүүлэхээр болсон байна.



Эрүүл мэндийн төв нь өөрсдийн нөөц хөрөнгөөр Эмнэлгийн тусламж үйлчилгээнд Сувилахуйн тэргэнцэр 2ш, Парাপин хайлуулагч, Автоклав, лаа, зажим 10ш нийт 5 төрлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлийг 1,048,000 төгрөгийн хөрөнгөөр худалдан авсан.



Салхинцэцэг өвчний гаралт ихсэж байгаа тул цэцэрлэгийн хүүхдүүдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 5 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1044 хүүхдийг хамруулж ангийн багш болон эцэг, эхэд нь зөвөлгөө өгч ажилласан.



СОЁЛЫН ТӨВ

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах баярын өдрийг тохиолдуулан Соёлын төвөөс "Орчлонгийн сайхан бүсгүйчүүд тандаа", Монгол улсад зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсаны 98 жилийн ойг тохиолдуулан "Орчлонгийн сайхан эрчүүд танаа" хүндэтгэлийн тоглолтуудыг соёлын төвийн дэргэдэх бүжгийн "Шивээн ганхаа" хамтлаг, сумын авьяаслаг залуучуудаас бүрдүүлэн баг 2019 оны 3 дугаар сарын 08, 18-ны өдрүүдэд зохион байгуулсан.



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Аймгийн нэгдсэн эмнэлгийн доторын тасгийн эмчтэй хамтран сумын хөгжлийн бэрхшээлтэй 24 иргэнд эрүүл мэндийн сургалт зохион байгуулж сургалтанд хамрагдсан иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэт хамруулж зөвлөгөө өгч ажилласан.



Зорилтот өрхийн хөгжил хамгаалалыг сайжруулах үндэсний хөтөлбөрт хамрагдсан 16 өрхөд “Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах” сургалтыг 3-р сарын 20-ны өдөр зохион байгуулсан.



НИЙГМИЙН БОДЛОГО

Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрүүдийг 2019 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр ажлын хэсэг төлөвлөгөөг хэлэлцэн боловсруулж, батлууллаа. Үүнд:

Сумын “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр-ийг 3 зорилтын хүрээнд 12 ажлыг 6.5 сая төгрөгөөр, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийг 3 зорилтын хүрээнд 11 ажлыг 4.5 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус хэрэгжүүлэхээр баталсан.

Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу ахмад настнуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор сумын Ахмадын хороотой хамтран “Ахмад мисс-2019” урлагийн арга хэмжээг 2019 оны 03 сарын 06-нд “Авьяаслаг ахмад” арга хэмжээг 2019 оны 03 сарын 18-нд тус тус зохион байгуулж, нийт 80 гаруй ахмад настныг хамрууллаа.



УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний бүртгэлийн үйлчилгээг 36 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 3 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.

3-р сард газраа анх удаа өмчилж авч байгаа 11 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна.

Иргэдээс 3-р сард 16 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэсэн.

Мөн энэ сард суманд орон нутгийн шилжүүлэггүй хөдөлмөр эрхэлж буй иргэдийн судалгааг байгууллага бүрээр гаргаж сумын Засаг даргын албан тоотоор хүргүүлэхээр бэлдээд байна. Үүнд: ШОХК-нд 49, Эрүүл мэндийн төвд 1, 3-р цэцэрлэгт 1, 3-р сургуульд 4, ЗДТГ-т 1, нийт 55 албан хаагч ажиллаж байна.

Иргэний гэр бүл байдлын статистик мэдээ тайлан болон Иргэний бүртгэлийн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, үнэт цаасны тайлан, үнэт цаасны орлогын тайлан зэргийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлээд байна.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2019 ОНЫ 03 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	9				9	6	3
Төрсөн эх	2	9				9		9
Бүртгүүлсэн гэр бүл	3	5				5	5	5
Нас баралт	4	3				3	2	1
Цуцалсан гэр бүл	5	-				-	-	-
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	20				20	9	11
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	-				-	-	-

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН ИРГЭНИЙ БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНЭЭС
ОРСОН ОРЛОГО**

2019,03,25

Д/д	Үйлчилгээний нэр төрөл	2019 оны 03-р сар					Бүгд	Тайлбар
		Үйлчилгээний хураамж 300200022101 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд			
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
1	Гэрлэлтийн бүртгэл	2500	2	5000				
2	Нийслэлээс шилжин ирсэн	5000	2	10000	1000	2	2000	
3	Өөр аймгаас шилжин ирсэн	3000	6	18000	1000	6	6000	
4	Сум доторх шилжилт	1500	3	4500	1000	3	3000	
Дүн		37500			11000			
Д/д	Үйлчилгээний нэр төрөл	Үйлчилгээний хураамж 300200022130 тоот дансанд		Бүгд	Тэмдэгтийн хураамж 300300123138 тоот дансанд		Бүгд	Тайлбар
		Нэг бүрийн үнэ	Тоо		Нэг бүрийн үнэ	Тоо		
		5	Иргэний үнэмлэх	15000	3	45000	3300	3
Дүн		45000			9900			
Нийлбэр дүн		82500			20900			
Нийт орлогын дүн		103400						

МАЛ ЭМНЭЛЭГ ҮРЖЛИЙН ТАСАГ

Суманд үйл ажиллагаа явуулж байгаа “ДЭОР” хувийн мал эмнэлэгтэй сумын мал эмнэлгийн тасаг гэрээгээ байгуулж орон нутгийн вакцинуудаа хүлээлгэн өгөөд байна.



Төлийн мэдээг 7 хоног тутам гаргаж Аймгийн ХХААГ-т хүргүүлж байна. 03-р сарын 22-ны байдлаар ингэ-2, ямаа-314, хонь-572, үнээ-3, нийт 891 мал төллөж, 891 төл бойжсон байна. Том малын зүй бус хорогдол 12 үүнд: 7

хонь, 5 ямаа байна.

БАЙГАЛЬ ОРЧИН



Сумын хэмжээнд нийтийн их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж 24-н ААНБ-ын 56 иргэн 4 га талбайн 12м³ хог хаягдалыг түүж цэвэрлэсэн. ШОХК-ийн гражийн урд талд үүссэн 188м³ хур хогийг цэвэрлүүлэн төвлөрсөн хогийн цэгт зөөж тээвэрлүүлсэн.

Түгээмэл тархацтай ашигт малтмал зөвшөөрөлгүй олборлож байсан Сүмбэр сумын иргэний үйлдэлийг газар дээр нь таслан зогсоож Ашигт малтмалын нөөц ашиглах гэрээг байгуулан хяналт тавин ажиллаж байна.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Сумын 2 дугаар баг 21 дүгээр зөрлөгийн баруун урд 50га газарт гэр бүлийн хэрэгцээний зориулалттай өмчлөлийн 1:1000 масштабтай байр зүйн зураг үйлдэх, боловсруулах ажлыг ОНХС-ийн 2,6 сая төгрөгийн хөрөнгөөр “Шинэ геодези” ХХК-иар гүйцэтгүүлэхээр 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдөр гэрээг байгуулаад байна.



2018 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажил болон 2019 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлуудыг гарын авлага болгон бэлтгэж 611 өрхөд олгож ажилласан.

2020 онд ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын саналыг багийн Засаг дарга нар батлагдсан маягтын дагуу нийт 611 өрх буюу сумын нийт өрхийн 56%-иас саналыг авч эрэмбэлээд байна.

МЭДЭЭ ГАРГАСАН:

МЭРГЭЖИЛТЭН

О.БОЛОРМАА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА

Д.ОТГОНЖАРГАЛ